

COVID19 халдварт өвчний шинжилгээний зардал  
болон холбогдох байгууллагад мэдэгдэл хийхгүй байх  
талаарх зааварчилгаа  
–Гадаадын иргэн

□ COVID19 халдварт өвчний шинжилгээнд хамрагдах шаардлагатай тохиолдол

- ① Эмчийн оношлогооны дагуу учир шалтгаан нь үл мэдэгдэх уушгины хатгалгаа туссан зэрэг COVID19 туссан байх магадлалтай иргэн
- ② Гадаадад зорчсон бөгөөд БНСУ-д орж ирснээс хойш 14 хоногийн дотор 37.5°C-с дээш халуурах, амьстгал давхцах, ханиалгах зэрэг шинж тэмдэг илэрсэн иргэн
- ③ COVID19 халдварт өвчин БНСУ-д нэг дор мөн нэг газраас олноороо илэр сэн тохиолдолтой ямар нэгэн байдлаар хамаатай бөгөөд 14 хоногийн дотор 37.5°C-с дээш халуурах, амьстгал давхцах, ханиалгах зэрэг шинж тэмдэг илэрсэн иргэн

□ Зааварчилгаа

- ① Дээрх тохиолдлын улмаас шинжилгээнд хамрагдах тохиолдолд иргэншил, ви зний ангилал хамаарахгүйгээр солонгос иргэний адилаар шинжилгээнд үнэгүй хамрагдана. Дээрх шинж тэмдэг илэрсэн тохиолдолд 1339 лавлах утаснаас лавласны дараа эрүүл мэндийн төв буюу ойрхон байрлах тусгай шинжилгээн ийг газар очино уу.
- ② Оршин суух визгүй (Хууль бусаар оршин сууж буй) иргэн COVID19 халдварт өвчний шинж тэмдэг илэрч эмнэлэгт үзүүлсэн тохиолдолд Гадаадын иргэн, харьятын газарт мэдэгдэхгүй бөгөөд албадан барьж хорихгүй.

- COVID19 халдварт өвчний шинж тэмдэг болон холбогдох мэдээллийн 1339 лавлах утаснаас, оршин суухтай холбогдох мэдээллийг Гадаад иргэдийн нэгдсэн лавлах төвийн 1345 утаснаас лавлах боломжтой.  
※ 1339 утаснаас түрүүлж лавлах хэрэгтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд доорх утас руу холбогдож гурвалсан холбоогоор орчуулга хийлгэх боломжтой.

- 1339(1345 болон 1330) Орчуулагчтай холбогдох боломжтой цаг болон холбогдох төвүүдийн мэдээлэл

	Цаг	Хэл
(1345) Гадаад хэргийн яамны харьяат Гадаад иргэдийн нэгдсэн лавлах төв	09:00~22:00	Англи хэл, Хятад хэл
	09:00~18:00	Япон хэл, Вьетнам хэл, Тайланд хэл, Малайз/Индонез хэл, Орос хэл, Монгол хэл, Бангладеш хэл, Пакистан хэл, Балба хэл, Камбож хэл, Мьянмар хэл, Франц хэл, Герман хэл, Спани хэл, Тагалог хэл, Араб хэл, сингаль хэл
(1330) Солонгосын Аяалал Жуулчлалын газрын Аяалал жуулчлалын лавлах төв	24 цаг	Англи хэл, Хятад хэл, Япон хэл
	08:00~19:00	Вьетнам хэл, Тайланд хэл, Малайз/Индонез хэл, Орос хэл